## ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН БОЛ ХААНААС ТУСЛАМЖ АВАХ ВЭ?

**Зөвлөгөө**



### ДАНУРИ ЛАВЛАХ ТӨВ ☎ 1577-1366

- 365 өдөр 24 цагийн турш зөвлөгөө болон орчуулгын тусламж

### ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЦАГААЧ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТӨВ

**Зөвлөгөө өгөх болон тусламж авах мэдээлэл өгөх**

- Хэнд хамаарах : Цагаач эмэгтэйчүүд ба тэдний гэр бүлийн гишүүд

**Хамгаалалт**



### ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЦАГААЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОРОГДОХ БАЙР

**Хамгаалалт, зөвлөгөө өгөх**

- Байранд орох хүн : Цагаач эмэгтэйчүүд ба тэдний гэр бүлийн гишүүд
- Байрлах хугацаа : 2 жил

**Байраар хангах**



### ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ЦАГААЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НИЙТИЙН БАЙР

**Байраар хангах (Хорогдох байранд байсан хүн)**

- Байранд орох хүн : Цагаач эмэгтэйчүүд ба тэдний гэр бүлийн гишүүд
- Байрлах хугацаа : 2 жил

**Бие даах**



### БИЕ ДААН АМЬДРАХЫГ ДЭМЖИХ ТӨВ

**Бие даахад туслах (Хорогдох байранд байсан хүн)**

- Байранд орох хүн : Цагаач эмэгтэйчүүд ба тэдний гэр бүлийн гишүүд
- Байрлах хугацаа : 2 жил

### ТҮРЭЭСИЙН БАЙРААР ХАНГАХ ТАНИЛЦУУЛГА

- Байранд орох хүн : Цагаач эмэгтэйчүүд ба тэдний гэр бүлийн гишүүд
- Байрлах хугацаа : 2 жил, 2 жилээр сунгах боломжтой



## ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН БОЛ ДАРААХ БАЙГУУЛЛАГУУДААС ТУСЛАМЖ АВАХ БОЛОМЖТОЙ.

**Зөвлөгөө өгөх төв**

- Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг гэх мэт хүчирхийллийн хохирогчид зөвлөгөө өгөх болон тусламж үзүүлэх
- Хууль эрх зүйн үнэгүй туслалцаа ба эмнэлгийн тусламж
- Виз оршин суух зөвшөөрөл сунгах, Солонгосын иргэншил авах тухай зөвлөгөө
- Солонгосын ахуй амьдралд дасан зохицох ба хүний эрхийн тухай зөвлөгөө зэрэг
- Хүчирхийлэлд өртсөн цагаач эмэгтэйчүүдийн хорогдох байр зэрэг холбогдох байгууллагатай холбож өгөх

**Хорогдох байр**

- Байр хоолоор хангах
- Зөвлөгөө өгөх болон эмнэлгийн тусламж
- Хэрэг үүсгэн шалгах, шүүх хуралд эрх хууль зүйн зөвлөгөө өгөх
- Оршин суух, нутаг буцахад дэмжлэг үзүүлэх
- Мэргэжил олгох сургалт болон ажилд орох мэдээллээр хангах, бие даахад дэмжлэг үзүүлэх
- Хохирогчийг хамгаалах бусад шаардлагатай ажил

**Нийтийн байр**

- Байр хоолоор хангах
- Бие даах болон бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх

**Бие даан амьдрахыг дэмжих төв**

- Мэргэжлийн технологийн сургалт (Мэргэжлийн үнэмлэх сертификат авахад дэмжих)
- Ажилд ороход дэмжлэг
- Дагалдан ирсэн хүүхдүүдийн асран хамгаалалт ба нийгмийн халамж
- Бие даах, бие даан амьдрах чадварын үндсийг тавих

### БИЕ ДААХЫГ ДЭМЖИХ МӨНГӨН ТУСЛАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ ТАНИЛЦУУЛГА

**Хүчирхийллийн хохирогч цагаач эмэгтэйчүүд нийгэмд дасан зохицож бие даахад тусламж үзүүлэх**

- Хэн хамрагдах : Хамгаалах байрнаас гарсны дараа бие даахыг эрмэлзэж буй цагаач эмэгтэйчүүд
- Мөнгөн дүн : 1 хүнд дээд тал нь 5 сая вон (Шалган тогтоосны дараа дүнг шийднэ)

몽골어

평등을 일상으로

Эрх тэгш байдлыг өдөр тутмын амьдралдаа

# ЦАГААЧ ЭМЭГТЭЙЧҮҮД ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАНИЛЦУУЛГА



여성가족부 Эмэгтэйчүүд гэр бүлийн яам | 복권위원회 Үндэсний сугалааны хороо

# ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн гишүүдийн хооронд биеийн болон сэтгэл санааны, эдийн засгийн хохирол учруулж буй үйлдэл

### БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Харилцагч талын зөвшөөрөлгүй хүчээр бэлгийн харилцаанд орох, бэлгийн харилцаанд орохыг албадах, дарамтлах, биеийн болон сэтгэл санааны, нийгмийн хувьд харилцагч талдаа хохирол учруулж буй үйлдэл

### БИЕЭ ҮНЭЛЭХ

Тодорхой бус этгээдээс мөнгөн болон бусад хөрөнгийн ашиг олох, олохоор тохиролцон үйлдэгдэж буй бэлгийн харилцаа, бэлгийн харилцаатай ижил төстэй бусад үйлдэл

## ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ БОЛСОН БОЛ ЭРГЭЛЗЭЛГҮЙ ТУСЛАМЖ ХҮСЭЭРЭЙ!!

## ЦАГААЧ ЭМЭГТЭЙЧҮҮД ӨРТӨЖ БУЙ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ?

**Бие махбодын хүчирхийлэл**
Эмэгтэйн биеийг цохих зэрэг бодит хүч хэрэглэн бэртэл гэмтэл учруулж буй үйлдэл

**Хэл ярианы болон сэтгэл санааны хүчирхийлэл**
Хэл ярианы хувьд харилцагч талаа шархлуулан зовоох, сэтгэл санааны хохирол учруулах

**Бэлгийн хүчирхийлэл**
Бэлгийн хувьд ичгүүртэй байдалд оруулах болон хүсээгүй байхад бэлгийн харилцаанд орохыг шаардах үйлдэл

**Эдийн засгийн хүчирхийлэл**
Амьдрах зардал мөнгө өгөхгүй байх, зөвшөөрөөгүй байхад өөрийн дураар өмч хөрөнгийг зарж үрэгдүүлэх үйлдэл

**Хянах**
Паспорт гэх мэт биеийн байцаалт бичиг баримтыг хураан авч өгөхгүй байх, эргэн тойрны хүмүүстэй харилцах харилцааг таслан зогсоох үйлдэл (Солонгос хэлний сургалт, өөрийн орны хүмүүстэй уулзах зэргийг хорин явуулахгүй байх)

## ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТВӨЛ ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

**Утсаар зөвлөгөө авах**
Данури лавлах төв
1577-1366
1366 Эмэгтэйчүүдийн шуурхай утас

Цагаач эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төвтэй холбогдож зөвлөгөө авч **орчуулагч зэрэг тусламж хүсэх**

Яаралтай
**112**
**Цагдаад мэдэгдэх**

Найз, танил, хөршөөсөө **тусламж хүсэх**

Хүчирхийлэлд өртөж гэмтсэн бол эмчилгээ хийлгэх **эмчилгээний түүх үлдээх**

**Нэн шаардлагатай эд зүйлээ бэлдэх**
Паспорт, гадаад иргэний үнэмлэх, бэлэн мөнгө, хөнгөн хувцас, холбоо барих утас гэх мэт

## ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН БОЛ ХААШАА ХОЛБОО БАРИХ ВЭ?

**☎ 1577-1366 Данури лавлах төв**
- 365 өдөр 24 цагийн турш яаралтай тусламж
  Цагаач эмэгтэйчүүд болон хосолмол соёлт гэр бүлд зориулсан ахуй амьдралын мэдээлэл өгөх болон нэгдсэн тусламж
- 13 хэлээр зөвлөх үйлчилгээ болон аман орчуулгын үйлчилгээ
  Солонгос хэл, Вьетнам хэл, Хятад хэл, Тагалог хэл(филиппин), Монгол хэл, Орос хэл, Тайланд хэл, Кхмер хэл(камбож), Япон хэл, Узбек хэл, Лаос хэл, Непал хэл, Англи хэл.

**Хүчирхийлэлд өртсөн цагаач эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв**
- (Сөүл) 070-8829-1366
- (Дэгү) 053-944-2977
- (Инчеон) 032-446-0091
- (Канвон) 033-261-4613
- (Чунгбүг) 043-223-5253
- (Чунгнам) 041-566-1366
- (Жонбүг) 063-255-1366
- (Жоннам) 061-282-1562
- (Чэжү) 064-722-6242

**Цагдаагийн дуудлага ☎ 112**
- Газар дээр нь очих болон шуурхай хамгаалалтад авах

**Эмэгтэйчүүдийн шуурхай утас ☎ 1366**
- 365 өдөр 24 цагийн турш яаралтай зөвлөгөө • түр хатгаалалтад авах • аврах тусламж
- Эмнэлгийн тусламж, хууль эрх зүйн зөвлөгөө болон мэргэжлийн байгууллагтай холбож өгөх ※ Солонгос хэл дээр явагдана.